



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/65

Жаргалтхаан

**Гэрээ байгуулж, санхүүжилтийн
эрх олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.4, 59.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2024 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7,000,000 (долоон сая) төгрөгийн хөрөнгөөр хийгдэх “Хүүхдийн тоглоомын талбайн засвар, тохижилт”-ын ажлын гэрээг Жаргалтхаан тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газартай байгуулж санхүүжүүлэх эрх олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлийг харгалзан санхүүжилтийг олгохоор гэрээ байгуулан батлуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Мөнхдэлгэр)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Ганбат)-д даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ